

МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ХИЙ БҮРЭЛДСЭН
ӨВЧНИЙ ЭМ НАЙРЛАГЫГ СУРВАЛЖ БИЧГҮҮДЭЭС ТОДРУУЛАХ НЬ

Д.Мөнх-Энэрэл¹, Б.Буянт¹

¹Өвөр монголын үндэстний их сургууль

*eeenee827@gmail.com, Утас: 88559454

IDENTIFYING THE PHARMACEUTICAL FORMULATION OF GYNECOLOGICAL KHII
BURELDSEN DISEASE IN THE MONGOLIAN TRADITIONAL MEDICINE FROM PREVI-
OUS REPORTS

Munkh-Enerel D¹, Buyant B¹

¹Inner Mongolian University of Nationalities

*eeenee827@gmail.com, Phone: 88559454

УЛАМЖЛАЛТ АНАГААХ
УХААНЫ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
ХИЙ БҮРЭЛДСЭН
ӨВЧНИЙ ЭМ НАЙРЛАГЫГ
СУРВАЛЖ БИЧГҮҮДЭЭС
ТОДРУУЛАХ НЬ

ABSTRACT

Introduction:

A gynecoloic qisu syndrome lasts for long time and shows signs of chronic khii bureldsen disease and causes a gynecological khii bureldsen disease at whole-body level. The disease often occurs in hospitals, and it is one of the main gynecological diseases in Mongolian traditional medicinal hospitals³. The problem of diagnosing and treating the disease with traditional medicine is the reason for the research.

Methods:

The documentary research method was used, and the main research materials were in Mongolian scripts of Ikh Yuteg Yondongombo, “Four Medical Tantras”², Luvsanchoympil “Jeduininkhor”⁴, Disren Sanjaajamtsin “Khukh Binderiya”⁵, “Pharmaceutical Formulation of Mongolian Medicine”¹³ As auxiliary materials, Mongolian scripts of the Mongolian editions of Jigmeddanjinjamts “Tungagajad”³, Yondongjamts “Treatment Booklet of Tibetan Medicine”⁶, Jambalchoynkhor “Four Keys of the Sea of Charms”⁷, Jigmeddanjanjamts “Courageous Treatment Concepts”¹⁰, and Ishbaljir “Four Springs”¹¹ were used.

At the meeting of the academic council of the Inner Mongolian National University, permission was obtained to conduct the research. Furthermore, since this research is documentary research, we have taken care not to violate the copyright by mentioning the name of the author of the book or work every time it is quoted.

Conclusion:

Due to the improper food and drinks that increase khii /rlung/, gynecological khii bureldsen disease formation is caused by the longtime of untreated or incorrect treatment, and the disease develops slowly and chronically. As causes, conditions, pathophysiology, and differentiation between the causes of gynecological khii bureldsen diseases are similar in meaning, it shows that the ancient reports and works are related to each other.

In gynecological khii bureldsen disease, the selection of medicine with warm characteristics to suppress the rlung is based on the yin yang theory of Eastern philosophy which is the main method to suppress the cool characteristics of rlung.

Key words: *khii bureldekh, pharmaceutical contents, documents*

Үндэслэл:

Шээс бэлгийн тогтолцооны өвчнүүдийн бүтцийг харахад 2021 онд сувганцрын өвчнүүд 44.0 хувь, эмэгтэйн аарцгийн эрхтэний үрэвсэлт өвчин 16.3 хувь, эм бэлэг эрхтэний үрэвсэлт бус өвчин 8.4 хувь, шээс ялгаруулах тогтолцооны бусад өвчин 7.2 хувь, эр бэлэг эрхтэний өвчнүүд 9.2 хувь, хөхний өвчин 3.2 хувь, бөөрний түүдгэнцрийн өвчнүүд 2.6 хувь, бөөрний дутмагшил 2.9 хувь, шээс чулуужих өвчин 2.1, цистит 4.1 хувийг тус тус эзэлж байна.¹ Үүнээс үзэхэд эмэгтэйн аарцгийн эрхтэний үрэвсэлт өвчин хоёрдугаарт, эм бэлэг эрхтэний үрэвсэлт бус өвчин дөрөвдүгээрт бичигдэж байгаа нь эмэгтэйчүүдийн өвчлөл тулгамдсан асуудал болж байгааг харуулж байгаа ба эмэгтэйчүүдийн өвнийг оношлох эмчлэх асуудал тулгарч байна.

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн эмчилгээний үндэст: Эмэгтэй хүн бол хөх, хүүхэн хэвтэш ба сарын хиртэй болохоор эрэгтэй хүнээс ялгаатай юм. Биеийн долоон тамирын сүүлийн хир болох цагаан, улаан 2 дусал буй. Үүний улаан нь сарын хир болж арван хоёр наснаас тавин нас хүртэл цувирна. Хүүхэн хэвтэшийн дотор дусал тогтож үр хүүхэдтэй болно. Цагаан дусал нь хөхөнд дэлгэрэх ба тачаал болно. Үүнд идээ, явдал, элдэв нөхцөлөөр хүүхэн хэвтэшийн өвчин тав, судлын өвчин арван зургаа, бэтэг өвчин ес, хоёр зүйлийн хорхойн өвчин зэрэг эмэгтэй өвчин гучин хоёр, жирэмсэн эмэгтэйн өвчин наймтай нийт дөч болно. Үүнд ерөнхийд нь засах, тус бүрт нь засах, эгэл өвчнийг засах гурван зүйл буй. Эмэгтэй өвчнийг ерөнхийд нь цус бүрэлдсэн, хий бүрэлдсэн хоёр буй. Цус бүрэлдсэнг 10 зүйл, хий бүрэлдсэнг 6 зүйлээр тус бүр ангилдаг.² хэмээн өгүүлсэн байдаг. Эмэгтэйчүүдийн өвчин тэр дундаа эмэгтэйн хий бүрэлдсэн өвчнийг эрт үеэс бид анагааж ирсэн ч өнөө цагт тус өвчнийг орчин

цагийн анагаах ухаанаар оношлон эмчлэх нь дийлэнх бөгөөд уламжлалт анагаах ухаанаар оношлох эмчилэх нь дутмаг байгаа тул түүнийг тодруулах нь чухал байна.

Эмэгтэйн цус бүрэлдсэн өвчин удааширч архагшаад хийн хувь дийлэнх шинжүүдийг үзүүлэх бөгөөд бүх биеийн чанартай нэг зүйлийн эмэгтэйн хий бүрэлдсэн өвчнийг үүсгэдэг. Тус өвчин эмнэлэг дээр олон тохиох бөгөөд монгол эмнэлэгийн эмэгтэйн гол өвчний нэг зүйл болдог.³ Тус өвчнийг уламжлалт анагаах ухаанаар оношлон эмчлэх асуудал орхигдох хандлагатай байгаа нь судалгааны үндэслэл болсон юм.

Зорилго:

МУАУ-ы эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчний мөн чанар болон эм найрлагыг сурвалж бичгийн судалгаагаар дамжин судлахыг зорилго болголоо.

Зорилт:

1. Эмэгтэйн хий бүрэлдсэн өвчний ухагдахууныг тодруулах
2. Эмэгтэйн хий бүрэлдсэн өвчний эм найрлагыг харьцуулан тодруулах

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга аргачлал:

Эх бичиг сурвалж бичиг судлалын арга ашигласан бөгөөд судалгааны гол материалд Их Ютэг Ёндонгомбо “Анагаах ухааны дөрвөн үндэс”², Лувсанчоймпил “Жидүйнинхор”⁴, Дисрэн Санжаажамцын “Хөх биндэрья”⁵, “Монгол анагаах ухааны эм найрлага судлал”¹³ бүтээлүүдийн монгол бичиг дээрх хэвлэлийг ашигласан. Туслах материалд Жигмэдданзинжамц “Тунгаагажад”³, Ёндонжамц “Төвд анагаах ухааны эмчилгээний товхимол”⁶, Жамбалчойнхор “Увдисын далайн дөрвөн түлхүүр”⁷, Жигмэдданзанжамц “Зоригт хамбын эмчилгээний ойлбор”¹⁰, Ишбалжир “Дөрвөн рашаан”¹¹ бүтээлүүдийн монгол бичиг

дээрх хэвлэлийг ашиглалаа.

Өвөр монголын үндэстний их сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар судалгааны сэдэв, арга аргачлалыг батлуулж судалгаа хийх зөвшөөрөл авсан ба энэхүү судалгаа нь сурвалж бичгийн судалгаа учир ном, бүтээлийн зохиогчийн нэрийг ишлэл авсан тухай бүртээ дурдан зохиогчийн эрхийн зөрчил үүсгэхгүй байхад анхаарсан болно.

Үр дүн:

Эмэгтэйн хий бүрэлдэх өвчний шалтгаан, нөхцлийг “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Дөрвөн рашаан” зэрэг бүтээлүүдэд хурьцал хэтэрсэн ба үл тохирох идээнд хорлогдсоноос болно, харин “Хөх биндэрьяа”, “Рашааны дусал”, бүтээлүүдэд сарын хирээс болно, “Зоригт хамбын эмчилгээний ойлбор”-т урьдын үйл хийгээд явдал мөр буруудсан, адын нөхцөлөөр үүснэ, “Дугаржавын эмнэлгийн туршлага”-т хийг арвидулах идээ, явдал мөрийн нөхцөлөөр үүснэ хэмээн өгүүлсэн.

Эмэгтэйн хий бүрэлдэх өвчний өвчлөл зүйг “Хөх биндэрьяа”, “Төвд анагаах ухааны эмчилгээний товхимол”, “Саран гэрэлт эмчилгээний ном”, “Рашааны дусал”, “Дугаржавын эмнэлгийн туршлага” бүтээлүүдэд эмэгтэйн цус бүрэлдсэн өвчин хуучирч удаад, архагшин хий хавсарч тус өвчин болно гэж утга ойролцоо үзсэн. Харин “Тунгагажад”-д сарын хир нь шар ус лугаа холилдон хий түрж, тэр нь цул сав хийгээд судлын аймагт сарниснаар үүснэ хэмээн өгүүлсэн байна.

Судалгаанд ашигласан бүтээлүүд дундаас “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Жидүйнинхор”, “Хөх биндэрьяа”, “Дөрвөн рашаан”, “Лхантав” бүтээлүүдэд эмэгтэйн хий бүрэлдсэн өвчнийг толгой, яс, зүрх, бөөр, ходоод, гэдэс тус бүр зургаа хэмээн ялгаж өгүүлсэн байна. Толгой, яс, зүрх, бөөр, ходоод, гэдэс зэрэг эрхтэнд эмэгтэйн хий бүрэлдэх өвчинтэй хамааралтай шинж тэмдэг илэрдэг байна.

Table 1: Comparison of etiology, conditions, and pathology of khii bureldeh gynecological disease in scripts

No	Name	Etiology, Conditions	Pathology
1	Four Medical tantras	due to excessive contact and poisoning by inappropriate foods..	
2	Tungagajad		The monthly hir is formed by mixing the yellow water with the khii, and it is dispersed in the solid tank and the vein region.
3	Jiduininkhor		
4	Khukh Bideriya	It will be the sign of the month in which the first red complex has descended.	Just as blood was formed in the new age, khii was formed in the old age.
5	Treatment Booklet of Tibetan Medicine		When the disease is new, it is said that blood is formed, and when it is old, khii is formed.

Судалгаа, шинжилгээ

6	Four keys to the Sea of Charms		
7	Dugarjav hospital experience	Foods and events to improve khii.	Due to the delay of treatment of blood formation disease, wrong treatment, menstrual disease, and consumption of food and drink that clears khii after the disease has subsided, it causes khii in the reproductive organs and causes the disease of chronic slow formation of blood.
8	Moonlight Therapy Book		When it is new, it will be a disease of blood formation, and when it is old, it will be a disease of khii formation
9	Zorigt Abbot's Concept of Therapy	Past actions and events will occur due to wrong and bad conditions.	
10	Four Springs	due to excessive contact and poisoning from inappropriate food.	
11	Lkhantaw		
12	Pharmaceutical Formulation of Mongolian Medicine		Due to excessive sexual desire, 2 drops of white and red stick together in the uterus and cause a woman's disease.
13	Wang Yun Bo's Concept of Therapy		
14	Four Springs and Spring Drops	First menstruation.	In the new time, the blood formed in the old khii will be formed.

Үүнээс үзэхэд эмэгтэйн хий бүрэлдсэн өвчин нь хийг аривдуулах идээ ундаа, явдал мөрийн буруудлаас үүдэн хий дийлэнх өвчнийг үүсгэн архагшин хуучирснаар үүсч байгаа харагдаж байна.

Эмэгтэйн хий бүрэлдсэн өвчинд эм найрлага орсон бүх бүтээлд Сүгмэл 7-г гол болгон авсан байна. Мөн “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Тунгагажад”, “Дөрвөн рашаан” зэрэг бүтээлүүдэд Памбрай 7, “Тунгагажад”, “Дугаржавын эмнэлгийн туршлага”, “Монгол анагаах ухааны эм найрлага судлал” бүтээлүүдэд Гишүүн 6, “Тунгагажад”, “Монгол анагаах ухааны эм найрлага судлал”

бүтээлүүдэд Гурван үр 17, “Тунгагажад”, “Дугаржавын эмнэлгийн туршлага”, “Ван Юүн Бо-ын эмчилгээний ойлбор” бүтээлүүдэд Жамбрай 6, “Монгол анагаах ухааны эм найрлага судлал”-д Үндэс 17-г гол эмүүдээр сонгосон байна.

Table 2: A comparison of pharmaceutical compositions of khii bureldeh gynecological disease in scripts

No	Name	Pharmaceutical compositions
1	Four Medical tantras	Dedbon 14, Yuril 13, Pambrai 7, Sugmel 7
2	Tungagajad	Braiwu 17, Pambrai 7, Yuril 13, Rashnamjil, Rontal 6, Dedbon 14, Jumz 3, Dangun 4, Sugmel 7, Jambrai 6, Jirug 6
3	Jiduininkhor	Agar 17, Sorogzin 9, Sugmel 7
4	Khukh Bideriya	
5	Treatment Booklet of Tibetan Medicine	Agar15, Agar 35, Olmos 25, Darwu19, Darwu 11, Yuril 18, Darwu18, Renchinpalm (break the blood), Zandan 18, Zar 14, Ruda 21
6	Four Keys to the Sea of Charms	Sugmel 7, Melreg flower 7
7	Dugarjav hospital experience	Sugmel 7, Sojidnijil, Jambrai 6, Naru3, Jumz 6
8	Moonlight Therapy Book	Agar 8, Semeruu 8, Sugmel 7
9	Zorigt Abbot's Concept of Therapy	Sugmel 7, Tungalag 5, Ulzii 18
10	Four Springs	Dedbon 14, Yuril 18, Pambrai 7, Sugmel 7
11	Lkhantaw	Sugmel 7
12	Pharmaceutical Formulation of Mongolian Medicine	Gishuun 6, Sugmel 7, Undes 17, Three seeds 17,
13	Wang Yun Bo's Concept of Therapy	Rashnamjil, Sugmel 7, Jambrai 6, Dali16, Notsog 6, Marbo 3, Yunva 4, Zomo 6, Sarichun, Ruda, Sorogzinnorow
14	Four Springs and Spring Drops	

Эмэгтэйн хий бүрэлдсэн өвчинд сүгмэл 7, жамбрай 6, гишүүн 6, памбрай 7, гурван үр 17, үндэс 17 зэрэг бүлээн тэгш чанартай найралтыг гол эм болгон хэрэглэж бусад эмийг толгой, яс, зүрх, бөөр, ходоод, гэдэсний хий бүрэлдсэнд тохируулан тухайн өвчинд үндэслэн өгч байна.

Эмэгтэйн хий бүрэлдэх өвчинд сүгмэл 7-г гол болгон хэрэглэж байгаа нь харагдаж байна. Тус эмийн найрлагыг авч үзвэл сүгмэл, цагаан хур, эрхтэний гар, хэрээн нүд, задь, лиш, хар агарыг талх эмээр хэрэглэдэг ба бүлээн чанартай хийг дарж тамиржуулах чадалтай эм юм. Гол найрлага сүгмэл нь гошуун амттай,

бүлээн чанартай, тослог эрдэм бүхий илчийг сэлбэх, хийг дарах бөөрний сайн эм болж, илчийг сэлбэх, дуслыг сэлбэх эрхтэний гар болон шимжүүлэх төлжүүлэх цагаан хур, хийг дарах задь, лиш, хар агарыг, дусал цувирахыг зогсоох, хийг дарах хэрээн нүдийг хавсаргасан тул хийг дарж, тамиржуулах найрлагын чадал болжээ..

Хэлцэмж:

Эртний Энэтхэгийн Аюурведын анагаах ухаанаас улбаатай уламжлалт анагаах ухаанд эмэгтэйчүүдийн өвчин тэр дундаа хий бүрэлдсэн өвчний ухагдахуун, эм найрлагыг нарийн, тодорхой өгүүлсэн байгаа нь бидэнд

монгол анагаах ухааны эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчний тухай маш их ойлголт байгааг харуулж байна. Анагаах ухааны дөрвөн үндэс, Дөрвөн рашаан, Тунгаагаж, Жидүйнинхор, Хөх биндэрьяа, Арван найман гишүүнт, Саран гэрэлт эмчилгээний ном зэрэгт эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчний гол агуулга ухагдахууныг тодорхой өгүүлсэн нь гол тулгуур боллоо.

Б. Дэжидмаа нарын (2013) судалгаагаар зомошин 6 тан ба түүний гол найрлага дэлт харганы бэлдмэл тромбын бүтцийн үндсэн элемент болох фибриний чөлөөтэй байлгаж, судас тромбоор бөглөрөхөөс сэргийлэх үйлдэлтэйг тогтоосон¹⁷. Энэхүү судалгаа нь орчин цагийн шинжилгээгээр хийгдсэн бол бидний судалгаа сурвалж бичиг зохиолуудаас бидэнд бичиглэн ирсэн мэдлэгийг гаргаж ирснээрээ онцлог юм.

Эмэгтэйн хий бүрэлдсэн өвчнийг эмчлэхэд хамгийн түрүүнд ходоодны галын илчийг сайжруулан бөөрний хийг дарж хий цусыг тэгшитгэж савийг бүлээсгэж хүйтэн хий бүрэлдсэнийг арилган цусны тамирийг сайжруулж бөөр самсийн хийг гол болгон засна⁸.

МУАУ-ы эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчний ухагдахуун, эм найрлагыг танилцуулан, хий бүрэлдсэн өвчний онолын судалгааг баялагжуулан дээшлүүлэх ба онол эмчилгээний байдлыг сайжруулах, хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Тус өвчний талаар ухагдахуун, эм найрлагыг судалж, нэгтгэн дүгнэснээрээ танин мэдэхүйн болон практикийн нөгөө талаас оюуны том соёлыг бодитой, үнэн зөвөөр тайлбарлан таниулж буй хэрэг хэмээн үзэж байна.

Бидний судалгаагаар хий бүрэлдсэн өвчний ухагдахуун, эм найрлагыг хязгаарлаж

болохгүй юм. Бидэнд эртний сурвалж бичгээр өвлөж ирсэн арвин их мэдээлэл байгаа болно.

Дүгнэлт:

Бид судалгаандаа эмэгтэйн хий бүрэлдэх өвчний гол агуулга, ухагдахууныг тодруулан 15 гаруй сурвалж бичиг, ном бүтээлийг нэгтгэн судалж, харьцуулан тайлбарлав. Зарим сурвалж бичиг, ном бүтээл дотор агуулга давтагдсан тохиолдол олон байлаа.

Эмэгтэйн хий бүрэлдэх өвчний талаар сурвалж бичиг ном зохиолуудыг олж тогтоон, тус өвчний талаар гол агуулга, ухагдахууныг нарийн судалж, нэгтгэн дүгнэснээрээ оюуны соёлыг бодитой, үнэн зөвөөр тайлбарлан таниулж буй хэрэг юм.

Ном зүй:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төв, *Эрүүл мэндийн үзүүлэлт 2021, 2022, 5, 122.* http://hdc.gov.mn/media/uploads/2022-05/ERUUL_MENDIIN_UZUULELT_2021.pdf
2. Ютэг Ёндонгомбо, Анагаах ухааны дөрвөн үндэс, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1978, 6, 674-688.
3. Жигмэдданзинжамц, Тунгаагаж, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999, 7, 97-99, 217-221.
4. Лувсанчоймпил, Жидүйнинхор, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1999, 5, 271-275.
5. Дисрэн Санжаажамц, Хөх биндэрьяа, Өвөр монголын хэвлэлийн бүлэг, Өвөр монголын шинжлэх ухааны техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2015, 12, 252-260, 264-266.
6. Ёндонжамц, Төвд анагаах ухааны эмчилгээний товхимол, Шилийн гол, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо,

- 2000,12, 103-104, 260-264.
7. Жамбалчойнхор , Увдисын далайн дөрвөн түлхүүр, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2010, 5, 226-229.
 8. Дугаржав, Дугаржавын эмнэлгийн туршлага, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1992, 12, 274-276.
 9. Өвөр монголын хятад монгол эмнэлгийн судлах газар найруулан орчуулсан, Саран гэрэлт эмчилгээний ном, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо 1999, 4, 337-341.
 10. Жигмэдданзанжамц, Зоригт хамбын эмчилгээний ойлбор, Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2012,3, 124-128.
 11. Ишбалжир, Дөрвөн рашаан, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1998,12, 200-202.
 12. Төмөр харгуулан буулгав, Лхантав, Үндэстний хэвлэлийн хороо, 1987,8, 478-486.
 13. 21 дүгээр зууны бүх улс эм эмнэлэгийн дээд сургуулийн монгол анагаах ухааны тусгай мэргэжлийн заах бичгийг найруулан хянах зөвлөл, Монгол анагаах ухааны эм найрлага судлал, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 2007,1, 272-293.
 14. Ван Юүн Бо, Ван Юүн Бо-гийн эмнэлэгийн ойлбор, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1985,12, 296-304.
 15. Бай Чин Юүн эрхлэн найруулав, Дундад улсын анагаах ухааны нэвтэрхий толь Монгол анагаах ухаан (доод), Өвөр монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 1987,7, 328-332, 907-908.
 16. Ишбалжир, Дөрвөн рашаан, Рашааны дусал, Шилийн гол, Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1998,12, 407-409.
 17. Дэжидмаа Б., Уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг зарим эмт бодисын цусны бүлэгнэлтэнд үзүүлэх нөлөөг судлах асуудалд. АУ-ы докторын зэрэг (PhD) горилсон нэг сэдэвт бүтээл, УБ, 2013, 4.

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор Г.Энхжин*